# ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
## /2024 оны жилийн эцсийн байдлаар/

| Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги /арга зам/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Санхүүгийн эх үүсвэр | Биелэлт | ***Үнэлгээ* (*хувь*)** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Арга хэм жээ** | **Зорилт** |
| **Нэг. Ерөнхий чиг үүргийн нэр: Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт** | | | | | | | | |
| **1.1. Үндсэн чиг үүргийн нэр:** Салбарын хууль тогтоомж, түүн<br>**1.2.**<br>**1.3.**<br>**1.4.** ий үзэл баримтлал, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бодлогын удирдамжаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаад төсөл, хөтөлбөр, олон улсын байгууллагуудын арга хэмжээ хоорондын уялдааг хангаж, салбарын бодлоготой уялдуулах, салбарын чиглэлээр иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн болон жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, шинжлэх ухаан, технологи, инновац, маркетингийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, зөвлөгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт-1. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангана. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4/, /ЗДҮАХ-ийн 4.2./ | Арга хэмжээ-1: Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын хэрэгжил тээр тооцно. | Хэрэгжи лтийн дундаж хувь 85% | 2021 он: Хэрэгжилт ийн хувь 90%<br>2022 онд: Хэрэгжилт ийн хувь 95%<br>2023 онд: Хэрэгжилт ийн хувь 100%<br>2024 онд: Хэрэгжилт ийн хувь 100 % | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 184.0 сая.төг<br>2021 онд: 46.0<br>2022 онд: 46.0<br>2023 онд: 46.0<br>2024 онд: 46.0 | УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого", аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 63 дугаар тогтоолоор "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр" батлагдаж, хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Тус хөтөлбөрийн хүрээнд хаврын тариалалт, намрын ургац хураалт, малын үзлэг ангилалт, ялган тэмдэглэгээ, хүн амын хүнсний улирлын нөөц бүрдүүлэх зэрэг ажлыг зохион байгуулан ажилласнаар тус хөтөлбөр 94.9 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжиж дууссан ба | 94.9 | 94.9 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоолоор хүчингүй болсон. | | |
| **Хоёр. Ерөнхий чиг үүргийн нэр: Мал аж ахуйн салбарын чиглэлээр** | | | | | | | | |
| **2.1.Үндсэн чиг үүргийн нэр:** Мал аж ахуйн үйлдвэрлэл, малын генетик нөөцийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, усан хангамжийг сайжруулах, малыг байгаль, цаг агаарын эрсдэлээс хамгаалах, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, малчны орлого нэмэгдүүлэх, малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, малын үржил, селекц, генетик нөөцтэй холбоотой бодлого, стратегийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, малын генетик нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээллийг тухай бүрд баяжуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт-1. Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын гениин санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4/, /ЗДҮАХ-ийн 7.3.3/ | Арга хэмжээ-1: Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах сургалтад хамруулах, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах | Чадавхи жуулах сургалтад хамрагдсан эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн тоо | - | 2021 он: -<br>2022 онд: 2-оос доошгүй сургалтад хамруулсан байна.<br>2023 онд: 2-оос доошгүй сургалтад хамруулсан байна.<br>2024 онд: 2-оос доошгүй сургалтад хамруулсан байна. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 30.0 сая.төг 2021 онд: - 2022 онд: 10.0 2023 онд: 10.0 2024 онд: 10.0 | 2023 онд аймгийн хэмжээнд 168 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж өмнөх оноос 27.0 хувиар өссөн байна. Үүнд: 30 иргэн мах, сүүний чиглэлийн 370 толгой үхэр, 11 иргэн махны чиглэлийн 414 толгой үхэр, 2 иргэн 269 толгой махны чиглэлийн нарийн ноост хонь, 12 иргэн 590 толгой гахай, 78 иргэн 3195 толгой шувуу, 15 иргэн 329 бүл зөгий, 4 иргэн 96 толгой туулайг тус тус өсгөн үржүүлж байна.<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан бод, бог малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтад 4 иргэн хамрагдаж ур чадвараа дээшлүүлсэн.<br>"Махны үхрийн аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн"-д махны үхрийн аж ахуй эрхэлдэг, эрхлэх сонирхолтой 9 иргэн, аж ахуйн нэгж, "Төв түмний сүүн соёл -2023" арга хэмжээнд сүүний үхрийн аж ахуй эрхэлдэг 5 иргэн, мах-ноосны чиглэлийн Суффолк үүлдрийн хонины аж ахуйтай танилцах аялалд 9 иргэн, нийт 23 иргэн, аж ахуйн нэгжийг тус тус хамруулан туршлага судлуулсан. Энэхүү ажилд орон нутгийн төсвөөс 5.8 сая төгрөгийг зарцуулсан.<br>"Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран "Сүүний технологи, эрүүл ахуйн зохистой дадал" сэдэвт сургалтыг зохион байгуулж эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа явуулдаг 15 иргэн, аж ахуйн нэгж оролцуулан мэдээллээр хангасан.<br>2024 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөө аж ахуйн их сургууль, Мал аж ахуйн биотехнологийн сургуультай хамтран эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 66 хүн хамрагдаж өндөр ашиг шимт малыг төрөлжүүлэн, өсгөн үржүүлэх, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, олон наст тэжээлийн ургамал тариалах, орон нутгийн түүхий эдээр дарш бэлтгэх арга технологийг эзэмшсэн.<br>Төвийн бүсийн эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэхэд авч хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд хариуцлагатай мал үржүүлэг технологийн хэлэлцүүлэг болон “ШИЛМЭЛ МАЛ-2024” үзэсгэлэн худалдаанд манай аймгаас 4 эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч оролцож туршлага судалсан. | | |
| | Арга хэмжээ-2: Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх ажлыг өргөжүүлэн, фермерүүдийг дэмжих | Дэмжлэгийн тоо /мөнгөн дүн/ | Үхрийн фермер 15, гахай фермер 1, тахианы аж ахуй 5, зөгийн 14 аж ахуйн нэгж | 2021 он: -<br>2022 онд: Төсөл хөтөлбөрт хамруулан дэмжсэн байна.<br>2023 онд: Төсөл хөтөлбөрт хамруулан дэмжсэн байна.<br>2024 онд: Төсөл хөтөлбөрт хамруулан | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр Нийт: 1,800.0 сая.төг<br>2021 онд: -<br>2022 онд: 600.0<br>2023 онд: 600.0<br>2024 онд: 600.0 | 2021-2022 онд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 5 иргэн, аж ахуйн нэгжид 332.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. 2023 онд “Хоршоо хөгжүүлэх сан"-аас мах, сүүний чиглэлийн үхэр сүргийн чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд 6 иргэнд 138.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч фермерүүдийг дэмжих ажлын хүрээнд "Эрдэнэт хот орчмын сүүний үхрийн фермерүүдийн холбоо"-нд ногоон тэжээл боох төхөөрөмж худалдан авахад орон нутгийн төсвөөс 8.0 сая, Прогресс төслөөс 7.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд эрчимжсэн мал аж ахуйн | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дэмжсэн байна. | | чиглэлээр 3 аж ахуйн нэгж, 1 иргэнд нийт 3.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.<br>2023 оны байдлаар аймгийн хэмжээнд 168 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа нь өмнөх оноос 27.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>2024 онд хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж улсын төсвийн 8.5 сая төгрөгийн хөрөнгөөр "Чиглэл" ХХК-д үйлдвэрлэгдсэн хүнсний зориулалтын савыг орон нутгийн сүү боловсруулах 2 үйлдвэр, сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг 16 малчин, фермерүүдэд олгож дэмжлэг үзүүлж, аймгийн хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах боломж бүрдсэн.<br>Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангаас мал аж ахуйн чиглэлээр “Арга билиг арвин сүрэг” хоршоонд 100 сая төгрөгийн зээл олгосон.<br>Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас махны чиглэлийн үхэр өсгөн үржүүлэхээр Төмөрт Агро ХХК 200.0 сая төгрөг, Тэнүүн буянт ХХК 197.5 сая төгрөг, Сүүний үхэр өсгөн үржүүлэхээр Роял Алтай Констракшн ХХК 300.0 сая төгрөг нийт 4 аж ахуйн нэгж 797.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. | | |
| | Арга хэмжээ-3: Аймгийн өвс, тэжээлийн | Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ. | өвс 190 тн, тэжээл 70 тн | 2021 он: Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 221 дүгээр тогтоолоор аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүй нөөцөд 160 тонн өвс 50 тонн тэжээл бэлтгэхээр төлөвлөгдсөнөөс нийт 275 тонн өвс 53.9 тонн тэжээлийг | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүйн нөөцийг бүрдүүлэх | | | 2022 онд: Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ.<br>2023 онд: Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ.<br>2024 онд: Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ. | Нийт: 220.0 сая.төг<br>2021 онд: 40.0<br>2022 онд: 60.0<br>2023 онд: 60.0<br>2024 онд: 60.0 | бэлтгэсэн. Үүнд аймгийн аюулгүйн нөөцөд 100 тонн өвс 40 тонн тэжээл Баян-өндөр сумын нөөцөд 100 тонн өвс 13.9 тонн багсармал тэжээл Жаргалант сумын нөөц 75 тонн өвс тус тус бэлтгэсэн. 2022 онд аймгийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 37.5 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 118 тн өвс, 35.9 тн тэжээл, нийт 218 тн өвс, 73.4 тн тэжээл бэлтгэж аймаг, сумын аюулгүйн нөөцийг 100 хувь бэлтгэсэн.<br>Аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын 32 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 15/02 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг хангасан.<br>Аймгийн аюулгүйн нөөцөд өвс 200 тн, тэжээл 86.1тн-ыг бүрдүүлэхээр төлөвлөж, аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг 100 хувь бүрдүүлсэн. Орон нутгийн төсвөөс 75.0 сая төгрөг, Баян-Өндөр, Жаргалант сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлдэхэд орон нутгийн төсвөөс тус бүр 50.0 сая төгрөг зарцуулсан.<br>2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлдэхэд орон нутгийн төсвөөс 75.0 сая төгрөг, Баян-Өндөр сум 50 сая төгрөг, Жаргалант сум 71.7 сая төгрөг нийт 196.7 сая төгрөгийг зарцуулсан.<br>Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 60 тн өвс, 25.0 тн тэжээл, Жаргалант сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 50 тн өвс, 30 тн тэжээл, Баян-Өндөр суманд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 50 тн өвс, 20 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тн тэжээл, нийт 160 тн өвс, 75.0 тн тэжээлийг 100 хувь бэлтгэсэн. | | |
| Зорилт-2. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээг тогтвортой байлгана. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4/, /ЗДҮАХ-ийн 7.3.4./ | Арга хэмжээ-1: Худаг уст цэгийг шинээр гаргах болон сэргээн засварлаж малчдад эзэмшүүлэх | Шинээр гаргасан, сэргээн засварласан худгийн тоо | Бэлчээрт 71 худаг ашиглагдаж, малчин өрхийн 80% усаар хангагдсан. | 2021 он: -<br>2022 онд: 2 худаг шинээр, 2 худаг сэргээн засварлана.<br>2023 онд: 2 худаг шинээр, 2 худаг сэргээн засварлана.<br>2024 онд: 2 худаг шинээр, 2 худаг сэргээн засварлана. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр Нийт: 270.0 сая.төг<br>2021 онд: -<br>2022 онд: 90.0<br>2023 онд: 90.0<br>2024 онд: 90.0 | 2021 онд: бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор Жаргалант сумын Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Дулаан-Уул багийн хөөвөр шувууд зэрэг газруудад шинээр 2 худаг гаргасан. Мөн хавчиг наранд 2 худаг насос шинээр тавьж сэргээн засварласан. Үүний үр дүнд 43 өрхийн энэ 8,3 мянган толгой мал усаар хангагдах боломж бүрдсэн. 2022 онд: 2 худаг шинээр 2 худаг сэргээн засварлан завсарласан. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Дулаан-Уул Хүн багийн Хөөвөр шувууд зэрэг газруудад шинээр худаг гаргасан. Үүний үр дүн 43 өрхийн 8.3 мянган толгой мал усаар хангагдах боломж бүрдсэн.<br>2023 онд улсын төсвийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2, орон нутгийн төсвийн 230.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 худаг шинээр гаргаснаар 63 өрхийн 17.8 мянган толгой мал усаар хангагдсан.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд бэлчээрийн зориулалттай 86 худаг, уст цэг байгаагаас инженерийн хийцтэй худаг 80, усан сан 6 ашиглагдаж, байна.<br>Бэлчээрийн усан хангамжийг сайжруулахаар 2024 оны орон нутгийн төсөвт 1 худгийн хөрөнгө шийдвэрлэгдэж, Малчин багийн Цохионы өвөрт 1 худаг шинээр гаргах ажлыг “Ташрын хүрээ” ХХК гүйцэтгэсэн. Шинээр 1 худаг гаргаснаар 12 өрхийн 1500 толгой мал усаар хангагдаж, бэлчээрийн усан хангамж 87 хувьд хүрсэн.<br>Худгийн ундарга муудсан 1 худгийг гүйцэтгэгч “Далайн эрхэс констракшн” ХХК | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | засварлаж, 2 худгийг малчид өөрийн хөрөнгөөр сэргээн засварласан байна. | | |
| | Арга хэмжээ-2: Бэлчээрт үлийн цагаан оготны тандалт судалгаа хийх | Тандалт судалгаа хийгдсэн байна. | Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 30%-д хийсэн. | 2021 он: -<br>2022 онд: бэлчээрийн 10%-д<br>2023 онд: бэлчээрийн 10%-д<br>2024 онд: бэлчээрийн 10%-д хийсэн байна. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 6.0сая.төг 2021 онд: - 2022 онд: 2.0 2023 онд: 2.0 2024 онд: 2.0 | Орхон аймаг нийт 39.3 мянган га бэлчээрийн талбайтай. 2021-2023 онд үлийн цагаан оготнын тандалт судалгааг 4000 га газарт хийж гүйцэтгэхэд үлийн цагаан оготнын тархалт илрээгүй.<br>2024 онд нийт бэлчээрийн 10% буюу 4000 га талбайд үлийн цагаан оготны тандалт судалгаа хийхээс 2024 оны 05, 10 дугаар саруудад Ус, цаг уур орчны шинжилгээний төвтэй хамтран Жаргалант сумын Дулаан-Уул багийн Баруун, Зүүн булаг, Зэрэглээ, Цагаан хуст, Тугалч, Панзын далиу зэрэг газруудын 4000 га талбайд хийхэд хөнөөлт хортон мэрэгч, үлийн цагаан оготно илрээгүй. | 100 | 100 |
| Зорилт-3. Орон нутгийн онцлогт зохицсон ашиг шимийн чиглэлийн үүлдэр, омгийн цөм сүргийн малаар сайжруулна. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4/, /ЗДҮАХ-ийн 7.3.5/ | Арга хэмжээ-1: Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх | Ялган төвлөрүүлсэн бог малын хээлтүүлэгчийн эзлэх хувь | 496 толгой хуц, ухна тоологдсоноос 81% буюу 402 толгой хуц, ухныг 3 суурьт ялган төвлөрүүлсэн. | 2021 он: -<br>2022-2024 онд: Бог малын хээлтүүлэгчийн 80-аас дээш хувийг ялган төвлөрүүлнэ. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 150.0 сая.төг 2021 онд: - 2022 онд: 50.0 2023 онд: 50.0 2024 онд: 50.0 | 2021 онд Баян-Өндөр сумын 120 толгой, Жаргалант сумын 434 толгой, нийт хуц ухны 81.8%-ийг ялган төвлөрүүлж, үзлэг ангилалт хянан баталгаажуулалт, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан ажилласан. Аймгийн хэмжээнд 2023 оны эхэнд 848 хуц, ухна тоологдсоноос бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх ажлын хүрээнд 724 толгой хуц, ухна буюу 85.4 хувийг 4 суурьт ялган суурилж, мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад авч үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт, ялган тэмдэглэгээ хийж, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.<br>Бог малын чанарыг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 72 хуц, 40 ухна нийт 112 өсвөр хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьсан. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2023 онд махны чиглэлийн Суффолк үүлдрийн хуцны үрээр Монгол үүлдрийн 270 хонинд зохиомол хээлтүүлэг хийж ажилласан.<br>2024 оны эхэнд хуц-417, ухна-325 нийт-742 толгой эцэг бог мал тоологдсоноос хаврын үзлэг ангилалтаар 603 толгой хуц, ухна буюу 81.2 хувийг 4 суурьт ялган суурилж, мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад авч үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт, ялган тэмдэглэгээ хийж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.<br>Монгол үүлдрийн хуц-40 толгой өсвөр хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьж мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулсан.<br>2023, 2024 онуудад Баян-Өндөр, Жаргалант сумдын 64 малчин өрхөд 140 толгой бог малын хээлтүүлэгч ашиглуулах түрээсийн гэрээ байгуулан ажилласан.<br>Үүний үр дүнд Барга үүлдрээр сайжруулсан F1 төл 3400 толгой байна.<br>Бог малын чанарыг сайжруулсанаар махны үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдсэн. | | |
| | Арга хэмжээ-2: Мал сүрэгт үзлэг ангилалт, ялган тэмдэглэгээ хийх, бүртгэлжүүлэх эх ажлыг эрчимжүүлэх, бүртгэл | Үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн малын тоо | 35.8 мянган толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн. | 2021-024 онд жил бүр нийт богийн хээлтүүлэгчийг 100, богийн хээлтэгчийн 60 хүртлэх хувийг хамруулна. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв<br>Нийт: 24.0 сая.төг<br>2021 онд: 6.0<br>2022 онд: 6.0<br>2023 онд: 6.0 | Орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омог, хэвшлийн малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор адуун сүргийг хурдны чиглэлээр, үхэр сүргийг Сэлэнгэ, Алатау, Семменталь, Хар тарлан үүлдрээр, хонин сүргийг Монгол, Баяд, Барга хуцаар, ямаан сүрэгт Өлгийн улаан, Эрчмийн хар ухна зэргийг үндсэн сайжруулагчаар ашиглаж байна.<br>2022 онд аймгийн хэмжээнд 37000 толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн бөгөөд 668 толгой хээлтүүлэгч, 36332 толгой хээлтэгчийг | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн нэгдсэн санд хамруулах | | | | 2024 онд: 6.0 | хамруулсан. Нийт 5.6 мянган толгой малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.<br>2023 онд аймгийн хэмжээнд 37.5 мянган толгой малд үзлэг ангилалт, 2.0 мянган толгой үхэрт ялган тэмдэглэгээ хийсэн. Нийт богийн 848 толгой хээлтүүлэгчид буюу хээлтүүлэгчийг 100 хувь, нийт богийн 58.9 мянган толгой хээлтэгчийн 36.8 мянган толгой буюу 62.4 хувийг хамруулан малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.<br>2024 онд аймгийн хэмжээнд 40.0 мянган толгой малыг үзлэг ангилалтад хамруулан ажилласан.<br>Хавар, намрын үзлэг ангилалтад бог малын 742 толгой хээлтүүлэгч 39.2 мянган толгой хээлтэгчийг 100 хувь хамруулан анги, чанарыг тодорхойлон ажиллахад 7858 толгой буюу 20.0 хувь нь цөм сүрэг, 28652 толгой буюу 71.6 хувь нь үржлийн сүрэг, 3490 толгой буюу 8.7 хувь нь хэрэгцээний сүрэгт бүртгэгдсэн.<br>Мөн 1870 толгой үхрийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.<br>Сэлэнгэ үүлдрийн үхэрт малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлоход аймгийн хэмжээнд 2700 үхэр Сэлэнгэ үүлдрийн үндсэн хэв шинжийг хадгалж, анги чанарыг тодорхойлоход 282 толгой үхэр цөм сүрэгт бүртгэгдсэн.<br>Программд бүртгэснээр e-mongolia системээс малчин, мал бүхий этгээдийн тодорхойлолт авах, дэмжлэгт хамрагдах боломж бүрдсэн. | | |
| **Гурав. Ерөнхий чиг үүргийн нэр: Газар тариалангийн салбарын чиглэлээр** | | | | | | | | |
| **3.1.Үндсэн чиг үүргийн нэр:** Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд тариалангийн үйлдвэрлэлийн байгаль, цаг агаарын эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, үр, сортын шинэчлэл, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, таримал ургамлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн тогтвортой, хүртээмжтэй | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хангамжийг бий болгох тариалангийн үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй техник, технологи нэвтрүүлэн тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт-1. Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.1/, /ЗДҮАХ-ийн 7.3.1./ | Арга хэмжээ-1: Төмс, хүнсний ногооны техник шинэчлэлийг үргэлжлүүлэн, ашиглалтыг сайжруулан, агропарк байгуулах | Агропарк байгуулагдаж, техник, тоног төхөөрөмжийн техник шинэчлэл хийгдсэн байна. | Агро үйлчилгээний төвд 41.8 сая төгрөгийг шийдвэрлэн LOVOL-824 трактор худалдан авсан. | 2021 он: Агропарк байгуулах төсөл боловсруулан, санхүүжилт татсан байна.<br>2022 онд: Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн байна.<br>2023 онд: Агропаркийн үйл ажиллагаа хэвийн явагдана.<br>2024 онд: Агропаркийн үйл ажиллагаа хэвийн явагдана. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 240.0 сая.төг 2021 онд: 120.0 2022 онд: 120.0 2023 онд: - 2024 онд: - | 2021 онд Жаргалант сумын Засаг даргын захирамжаар Агро парк байгуулах 2.4 га газрын асуудлыг шийдвэрлэсэн. Тус газрыг 481 метр хашаагаар хашаажуулан Гүний худаг барих ажлыг ХХААГ, Жаргалант сумын ЗДТГ, Каритас Монгол ТББ хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, нарны эрчим хүчээр ажиллах 3 улирлын 480м2 хүлэмжийг агро паркийн талбайд барьсан. Худагт орон нутгийн төсвөөс 120 .0 сая зарцуулсан. Хүлэмж барих ажилд Каритас Монгол ТББ-аас 40 сая төгрөг зарцуулсан.<br>2022 онд Техник дундын төв нь нийт 147 иргэний 196.5 га талбайд 5 төрлийн үйлчилгээ үзүүлсэн.<br>2023 онд Техник дундын үйлчилгээний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн орон нутгийн төсвийн 177.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмж худалдан авч 10 төрлийн ажил үйлчилгээг давхардсан тоогоор 257 иргэнд үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 70.0 хувиар өссөн.<br>Агропаркийг түшиглэн Жаргалант суманд төмс, хүнсний ногооны 500 тн багтаамжтай бүрэн механикжсан зоорийг 2024 онд ашиглалтад оруулахаар барьж байна.<br>2024 онд Агропаркийн техник дундын төв нь нийт 6 зүтгэх хүчний трактор, 12 төрлийн тоног төхөөрөмжтэй үйл ажиллагаа явуулж, хаврын тариалалтад 251 иргэний 189 га талбайд 6 төрлийн үйлчилгээ, ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэх ажилд иргэдийн захиалгаар өвс хадах, тармах, хаман боох, төмс хураахад давхардсан тоогоор 343 иргэний 335.3 га талбайд 4 төрлийн үйлчилгээг үзүүлсэн бөгөөд дундын төвийн үйл ажиллагаа жигдэрсэн. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд “Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем”-ийг ашиглах, мэдлэг олгох сургалт, Орхон, Булган, Хөвсгөл аймгийн “Бүсийн тариаланчдын зөвлөгөөн”, Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийн багц сургалтуудын хөтөлбөрт “Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтыг сайжруулах, техник, технологийн шинэчлэл хийх зорилгоор тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх” тухай арга хэмжээний талаар сурталчлан таниулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд эхний хагас жилийн байдлаар Баян-Өндөр сумын 2 тариаланч трактор, тоног төхөөрөмж худалдан авч plant.mofa.gov.mn цахим системээр илгээснээр 97.0 сая төгрөгийн буцаан олголт авсан байна. | | |
| | Арга хэмжээ-2: Төмс, хүнсний ногооны талбайг хашаажуулах ажлыг зохион байгуулах | Хашаажуулалт хийгдсэн талбайн хэмжээ | Жаргалант суманд төмс, хүнсний ногооны 250 га талбайг хашаажуулсан. | 2021 – 2022-2024 онд: Төмс, хүнсний ногооны 20 га талбайг хашаажуулна. | Эх үүсвэр: Улсын төсөв Нийт: 84.0 сая.төг 2021 онд: - 2022 онд: 28.0 2023 онд: 28.0 2024 онд: 624.0 | 2019-2020 онд улсын төсвийн 200.0 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 193 иргэний эзэмшлийн 257 га төмс, хүнсний ногооны талбайг хашиж хамгаалсан. Үүнд Жаргалант сумын "Бөөн бургас"-т 10.2 км, Мухар буланд 15 км ногооны хашааг ашиглалтад оруулж, сумын Засаг даргын Тамгын газрын өмчид шилжүүлэн өгсөн.<br>2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Жаргалант сумын Бөөн бургастад 3.6 км хашаа шинээр барьж, 36-р точикт 1.5 км хашаа сэргээн засварласнаар 49 иргэний эзэмшлийн 51 га талбайг хашиж хамгаалсан.<br>2024 онд Жаргалант сумын тариалангийн талбайн хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах зорилгоор нийт 12 байршилд 140 км хашаа барихаар судалгааг гарган Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлснээр улсын төсвийн | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгө оруулалтаар 624.0 сая төгрөгийн өртөг бүхий тариалангийн талбайн хашааны төмөр бетон шон 24 мянган ширхгийг манай аймагт хуваарилсныг гэрээний дагуу татан авч иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгох ажлыг зохион байгуулсан. Тус ажил хийгдсэнээр нийт 4900 га тариалангийн талбайг хашиж хамгаалсан. | | |
| Зорилт-2. Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлж үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалангийн талбай, нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.1/, /ЗДҮАХ-ийн 7.3.2./ | Арга хэмжээ-1: Усалгааны тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй зээлээр худалдан авахад иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ажиллах | Дэмжлэгт хамрагдсан аж ахуй нэгжийн тоо, талбайн хэмжээ | 1 аж ахуйн нэгж 50 га талбайн инженерийн хийцтэй услалтын системийн дэмжлэгт хамрагдсан. | 2021 онд: Аж ахуйн нэгжийг услалтын системийн дэмжлэгт хамруулна.<br>2022 онд: -<br>2023 онд: Аж ахуйн нэгжийг услалтын системийн дэмжлэгт хамруулна.<br>2024 онд: - | Эх үүсвэр: Улсын төсөв болон төсөл хөтөлбөр Нийт: 600.0 сая төг<br>2021 онд: 300.0<br>2022 онд: -<br>2023 онд: 300.0<br>2024 онд: - 210.2 | 2021 онд аймгийн хэмжээнд төмс хүнсний ногоог гадаргуугийн усалгааг шуудуу болон бага оврын усалгааны тоног төхөөрөмж/намираа/ ашиглан тариалж байна. Жаргалант сум нь төмс хүнсний ногоог шуудуугаар услах боломжгүй талбайтай ногоочдыг дэмжин орон нутгийн төсвөөс 9.9 сая төгрөгөөр бага оврын усалгааны иж бүрдэл 6 ширхгийг авч дэмжин ажилласан. Үүний үр дүнд 15 га талбайг бага оврын усалгааны тоног төхөөрөмжөөр услах боломж бүрдсэн. 2022 онд инженерийн хийцтэй худагтай 10 га талбайд хүнсний ногоо тариалж 135 тн буюу га-аас 135 цн, гадаргын усалгаатай 273 га талбайд төмс тариалж 3072 тн буюу га-аас 112,5, хүнсний ногоо 493.2 га талбайд тариалж 5948 тн буюу га-аас 120 цн ургац тус тус хураан авсан.<br>2023 онд "Шинэ хөдөө-Орхон" төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 12 ширхэг 1 га талбай услах хүчин чадалтай бороожуулах услалтын системийг тариаланчдад олгосноор усалгаатай тариалангийн талбай нэмэгдсэн. Энэ онд төмс 145 га, хүнсний ногоо 455 га талбайд усалгаатай нөхцөлд тариалсан бөгөөд үүнээс гадаргуугийн усалгаатай 510 га буюу 85 хувь, усалгааны тоног төхөөрөмжөөр 90 га буюу 15 хувь байна. Усалгаатай нөхцөлд төмс 145 га-аас 1628 тонн буюу га-аас 112 цн, хүнсний ногоо 455 | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | га-аас 9520 тн буюу га-аас 209 цн ургац тус тус хураан авсан.<br>2024 онд төмс, хүнсний ногооны талбайд усны зарцуулалт багатай усалгааны дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх зорилгоор “Шинэ хөдөө-Орхон” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 1 га услах хүчин чадалтай 16 усалгааны системийг төслийн сонгон шалгаруулалт зарлан 12 иргэнд гэрээгээр эзэмшүүлсэн. Үүний үр дүнд төмс, хүнсний ногооны усалгаатай талбайн хэмжээ 16 га талбайгаар нэмэгдсэн.. | | |
| | Арга хэмжээ-2: Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Хөтөлбөрт хамрагдсан өрхийн тоо | Жил бүр 1000 өрхийг хөтөлбөрт хамруулсан. | 2021 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 30%<br>2022 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 60%<br>2023 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 80%<br>2024 онд: Хөтөлбөрийн хэрэг-жилт 100% | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 560.0 сая.төг<br>2021 онд: 110.0<br>2022 онд: 150.0<br>2023 онд: 40.0<br>2024 онд: 70.0 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, жил бүр шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган ажиллаж байна.<br>2023 онд орон нутгийн төсөвт 40.0 сая төгрөг тусгаснаар хөтөлбөрт хамрагдсан Баян-Өндөр сумын 26 багийн 500 өрхөд 5 төрлийн үрийн багц олгож, төмс, хүнсний ногоо тариалах гарын авлагаар ханган, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 80 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон 13 төрлийн 2.6 тн үрийг 235 өрх, аж ахуйн нэгжид олгосноор нийт 735 өрх, аж ахуйн нэгж 8 га талбайд төмс, 140 га талбайд хүнсний ногоо тариалсан.<br>Аймгийн хэмжээнд 2 иргэн, 11 аж ахуйн нэгж 2200 м.кв талбайд 3 улирлын хүлэмжийн аж ахуй эрхэлж байна. Өвлийн хүлэмжийн аж ахуй эрхлэхээр Засгийн газраас олгогдож буй хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар 2 аж ахуйн нэгжийн материал банк дээр судлагдаж байна.<br>Улсын төсвийн хөрөнгөөр "Үйлдвэрлэгч баг" төслийн хүрээнд 90 ширхэг, "Шинэ хөдөө-Орхон" төслийн хүрээнд 10 ширхэг, | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт 100 ширхэг хүлэмжийг иргэн, аж ахуйн нэгжид олгосноор хүлэмжийн талбай 1.2 га талбайгаар нэмэгдсэн.<br>Энэ онд 5.1 га талбайд хүлэмжийн тариалалт хийж, 305 тн ургац хураан авснаар өмнөх оноос 55 тн-р нэмэгдсэн.<br>Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран зохион байгуулсан "Хөдөө аж ахуйн технологи”-ийн сургалтад 45 өрхийн тариаланчийг хамруулсан.<br>Тус хөтөлбөрийн хэрэгжилт 98.0 хувьтай хэрэгжиж байна.<br>“Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөр”-ийГ хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын 2024 оны А/72 дугаар захирамжийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрт энэ онд Жаргалант сумын 500 өрхийг хамруулан, 30 тн төмсний үр, 50 кг шар лууван, 30 кг хүрэн манжин, 30 кг шар манжин, 25 кг урт сонгины үрийг олгосон. Үүний үр дүнд төмс 11 га, шар лууван 16 га, шар манжин 5 га, хүрэн манжин 5 га, урт сонгино 3 га талбайд тариалах үрээр ханган ажилласан.<br>Газар тариалангийн үйлдвэрлэлийн цахим бүртгэлийн систем болон “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”-ыг танилцуулах, төрөөс олгож буй урамшуулал, дэмжлэгт хамрагдахад системийг хэрхэн ашиглах, материалыг цахимаар бүрдүүлэх зэрэг багц сургалтыг зохион байгуулан мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.<br>Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувьтай байна. | | |
| **Дөрөв. Ерөнхий чиг үүргийн нэр: Хүнсний салбарын чиглэлээр** | | | | | | | | |
| **4.1.Үндсэн чиг үүргийн нэр:** Хүнсний үйлдвэрлэл, хангамж, худалдааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнсний болон хоол үйлдвэрлэлд үнэ цэнийн болон кластерийн сүлжээг хөгжүүлэх, хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, импортыг орлох болон экспортлох боломжийг нэмэгдүүлэх, аймгийн хүн амын хүнсний хангамжийг | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх, мэдээллийн цахим санд мэдээлэх, чиг үүрэг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт-1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.3/, /ЗДҮАХ-ийн 4.2./ | Арга хэмжээ-1: “Эрүүл Хүнс-Эрүүл Монгол Хүн” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж хүн амын хүнсний хэрэгцээт мах, төмс, гурилыг бүрэн, хүнсний ногооны 50-аас доошгүй хувийг орон нутгийн үйлдвэрлэлээс хангах | Хангамжийн хувиар тооцно. | Хангамж /хувь/: Малын мах-90.7, сүү-45.3, гурил-0.7, Төмс-100, хүнсний ногоо-72.6, жимс, жимсгэнэ-0.1 | 2021 онд: Хангамж: Малын мах-92.0, сүү-50.0, гурил-10.0, Төмс-100, хүнсний ногоо-60.0, жимс, жимсгэнэ-0.2<br>2022 онд: Хангамж:Малын мах-94.0, сүү-50.0, гурил-15.0, Төмс-100, хүнсний ногоо-65.0, жимс, жимсгэнэ-0.3<br>2023 онд: Хангамж: Малын мах-94.0, сүү-55.0, гурил-20.0, Төмс-100, хүнсний ногоо-70.0, жимс, жимсгэнэ-0.3<br>2024 онд: Хангамж: Малын мах-95.0, сүү-55.0, гурил-40.0, Төмс-100, | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 75.0 сая.төг 2021 онд: 25.0 2022 онд: 25.0 2023 онд: 25.0 2024 онд: - | "Эрүүл Хүнс-Эрүүл Монгол Хүн" хөтөлбөр нь 2020-2021 онд 85.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж дууссан бөгөөд Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон.<br>2023 оны жилийн эцсээр хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр давхардсан тоогоор нийт 112 үйлдвэр, цех бүртгэлтэйгээс 50 орчим нь тогтвортой үйл ажиллагаа явуулж, тус салбарын 16 аж ахуйн нэгж, 15 иргэн 3.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл, дэмжлэгт хамрагдан үйл ажиллагаагаа өргөжүүлснээр аймгийн боловсруулах салбарын үйлдвэрлэлтийн 15.8 хувийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлт эзэлж, 35.02 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 59.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт 3.6, борлуулалт 48.2 хувиар тус тус өсөж, хүн амын хэрэгцээт малын махны 77.2 хувь, сүүний 4.9 хувь, цагаан идээний 4.7 хувь, гурилан бүтээгдэхүүний 44.3 хувь, төмсний 43.3 хувь, өндөгний 6.1 хувь, хүнсний ногоог 100 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангасан.<br>"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Орхон аймагт 2022-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2022 оны 12/02 дугаар тогтоолоор батлуулан ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилт 85.7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.<br>2024 онд Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч 1 аж ахуйн нэгж 177.0 сая төгрөг, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөлөлттэй зээлд 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн | 85 | 85 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүнсний ногоо-75.0, жимс, жимсгэнэ-0.3 | | дэмжлэгт хамрагдсан. Үүний дунд төхөөрөмжийн шинэчлэлт хийгдэж, талх, хиаман төрлийн бүтээгдэхүүн 3 нэр төрлөөр нэмэгдсэн. 2024 онд Хүнс, хөдөө аж ахуйн хүүгийн хөнгөлөлттэй зээлээс хиам, талх үйлдвэрлэлийн 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нарийн боов, бялууны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2 аж ахуйн нэгж 277.0 сая төгрөгийн зээл тус тус авч, бялуун төрлийн бүтээгдэхүүний 1 аж ахуйн нэгж шинээр нэмэгдэж, хиам 4.9, нарийн боов 5.9, хэвийн боов 89.9, талх 52.9 хувиар үйлдвэрлэл өсч, аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт махны 73.6 хувь, сүүний 8.3 хувь, цагаан идээний 7.1 хувь, гурилын 3.6 хувь, гурилан бүтээгдэхүүний 59.2 хувь, төмсний 51.6 хувь, хүнсний ногооны 100 хувь, өндөгний 1.8 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангаж байна. | | |
| | Арга хэмжээ-2: Хаврын хүнсний улирлын нөөц бүрдүүлэх зорилгоор махны нөөц бүрдүүлэх | Хаврын хэрэгцээт махны хувь, бэлтгэсэн мах /тн/ | Хаврын хэрэгцээт махны 25%-буюу 301.1 тн мах бэлтгэсэн. | 2021 онд: 50-аас доошгүй хувийг хангана.<br>2022 онд: 50-аас доошгүй хувийг хангана.<br>2023 онд: 120.0 мян.тн<br>2024 онд: 50-аас доошгүй хувийг хангана. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 2.200.0 сая.төг 2021 онд: 400.0 2022 онд: 600.0 2023 онд: 600.0 2024 онд: 410.0 | Аймгийн хүн амын 2021, 2022 оны хаврын хэрэгцээнд нийт 450 тонн үхэр, хонь, ямааны махны нөөц бэлтгэн зах зээлд нийлүүлсэн.<br>Аймгийн хүн амын 2024 оны хаврын махны хэрэгцээнд үхэр, хонь, ямааны 200 тн махыг бэлтгэн нийлүүлэх гэрээг Аймгийн ЗДТГ-аас сонгон шалгаруулалтад тэнцсэн Эрдмийт ХХК, Жаргалант мах импекс ХХК-уудтай байгуулсан. 3 дугаар сарын 15 ны өдрөөс эхлэн 6 дугаар сарын 10 ны өдрийг хүртэл хугацаанд Баян-Өндөр сумын 17 багийн 29 цэг, Жаргалант суманд 2 нийт 31 цэгээр үхэр, хонины махыг Эрдмийт ХХК, ямааны махыг Жаргалант мах импекс ХХК бэлтгэн, ангилан савласан ястай үхрийн мах 1 кг нь 9000, хонины мах 1 кг нь 6400, ямааны мах 1 кг нь 4900 төгрөгийн үнээр хэрэглэгчдэд худалдаалсан. Хэрэглэгчдэд | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үхрийн мах 7800, хонины мах 8300, ямааны мах 5500 төгрөгийн хямд үнэтэй хүргэсэн. 2025 оны хаврын улирлын махны нөөц бүрдүүлэхэд 410.0 сая төгрөг Орон нутгийн төсөвт батлагдсан. Нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах зарыг нийтэд зарлан явуулж байна. Шалгаруулалтыг 12 сард багтаан хэлэлцэж, шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах ажил хугацаа хүлээгдэж байна. | | |
| Зорилт-2. Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.3/, /ЗДҮАХ-ийн 4.3./ | Арга хэмжээ-1: Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратегийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд хүнс, хоол үйлдвэрлэл эрхлэгчдэд давсны агууламжийг бууруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгч сургалт мэдээллээр ханган ажиллах | Давсны агууламжийн хувь | Бүтээгдэхүүний давсны агууламж 47.9 хувиар буурсан. | 2021 онд: -<br>2022 онд: Бүтээгдэхүүний давсны агууламж 50.0 хувиар буурна.<br>2023 онд: Бүтээгдэхүүний давсны агууламж 53.0 хувиар буурна.<br>2024 онд: Бүтээгдэхүүний давсны агууламж 56.0 хувиар буурна. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 15.0 сая.төг<br>2021 онд: -<br>2022 онд: 5.0<br>2023 онд: 5.0<br>2024 онд: 5.0 | 2021 онд: аймгийн хэмжээнд үйл ажиллагаа ажиллагаа явуулж буй хүнсний үйлдвэрийн 80% хоол үйлдвэрлэлийн 55% нь шим тэжээлийн үзүүлэлт, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлчийн 30% нь давсны агууламжийг хүнсний бүтээгдэхүүний шошго, хоолны цэсэнд тусгаж хэвшсэн. Хоол үйлдвэрлэл эрхлэгчдийн технологийн мөрдүүлэх зорилгоор хоолны илчлэг тооцох, технологийн карт боловсруулах 2 төрлийн 216 ширхэг зөвлөмжийг бэлтгэн хоол үйлдвэрлэл эрхлэгчдэд хүргүүлэн мөрдүүлэн ажиллаж байна. 2022 онд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, сувиллын байгууллагуудын эмч, хоол зүйч нарт давс, саахар чихрийн хэрэглээг бууруулах хэрэглэгчдэд эрүүл шим тэжээллэг хүнс, хоол олгох, хэвшил болгох талаар 3 удаагийн сургалтыг үе шаттай зохион байгуулж, нийт 84 мэргэжилтнийг хамруулсан. Мөн хүн амд хоол тэжээлийн боловсрол олгох сургагч багшаар 152-аар хүнийг бэлтгээд байна. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, сувилалын хоол, үйлдвэрлэлийн хоногт хүнс тэжээлээс авах давсны зохист харьцааг мөрдүүлснээр агууламжийг 50%-аар бууруулж зохист хэмжээнд хүргэсэн үр дүнтэй байна. Хүнсний боловсруулах | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 15 үйлдвэр, цехэд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний давсны орц найрлагыг бууруулах зөвлөмж мэдээлэл хүргүүлж ажилласан. Түүврийн аргаар орон нутагт үйлдвэрлэдэг 8 хүнсний бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлийн 9 дээж авч давсны агууламжийг тодорхойлоход бүгд зохист хэмжээнд хэрэглэж хэвшснээс гадна бүтээгдэхүүний давсны агууламжийг өмнөх оноос 51.8 хувиар бууруулсан байна.<br>2024 онд түүврийн аргаар орон нутагт үйлдвэрлэгддэг 10 хүнсний бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлийн 12 дээж авч давсны агууламжийг тодорхойлоход зохист хэмжээнд хэрэглэж хэвшсэн үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд бүтээгдэхүүний давсны агууламжийг суурь түвшингөөс 57.1 хувиар бууруулсан байна. | | |
| | Арга хэмжээ-2: Хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартын талаар үйлдвэрлэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх | Сургалтад хамрагдсан үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо | 20 үйлдвэрлэл эрхлэгчийг чанар стандартын сургалт хамруулсан. | 2021 онд: -<br>2022 онд: 20 үйлдвэрлэл эрхлэгч<br>2023 онд: 20 үйлдвэрлэл эрхлэгч<br>2024 онд: 20 үйлдвэрлэл эрхлэгч | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв<br>Нийт: 6.0 сая.төг<br>2021 онд: -<br>2022 онд: 2.0<br>2023 онд: 2.0<br>2024 онд: 2.0 | Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсээс "Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын шаардлагыг Шар тогтоосон эрх зүйн зохицуулалтууд" сертификаттай 8 цагийн сургалтыг зохион байгуулж, нийт 18 үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг хамруулан анхны шатны мэдлэгийг олгосон. ХХАА-н зохист дадал нэвтрүүлсэн үйлдвэрлэл 5 болж нэмэгдсэн. Эрдэнэт мах маркет ХХК 7 удаагийн сургалтаар 202 ажилтныг сурган чадавхжуулж, 2022 оны 9 сард Хүнсний аюулгүй байдлын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001-ийн 2дах удаагийн давтан баталгаажилтад амжилттай хамрагдан баталгаажилт авсан. 2023 онд хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийг хүнсний аюулгүй байдлын талаарх хууль эрх зүйн мэдлэг салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чадавхжуулах 1 сарын хөтөлбөрт сургалтыг BEST хөтөлбөр, Обзерв Консалтинг хүнсний | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аюулгүй байдлын зөвлөх байгууллагатай хамтран зохион байгуулж, хүнсний боловсруулах 35 үйлдвэр, цехийг нийт 5 удаагийн сургалтад хамруулан мэдлэг олгон сертификат гардуулав.<br>2024 онд Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулах, салбарын хууль, эрх зүйн орчны шинэчлэл, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 4 хяналтын чиглэлээр сургалт зохион байгуулсан. Сургалтыг Хөгжлийн шийдэл ТББ-аас хэрэгжүүлж буй Best хөтөлбөр, Ногоон шийдэл хөтөлбөр, Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран нийт 7 удаагийн сургалтад хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хоол үйлдвэрлэл, газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэгч 481 аж ахуйн нэгж, иргэний төлөөллийг хамруулсан.<br>Үр дүн: Сургалт зохион байгуулснаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч, үйлдвэрлэгчдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж, бүртгэл хөтлөлт, хууль, журам, стандартын хэрэгжилт өмнөх оноос 5%-иар нэмэгдэж 86.5%-д хүрсэн. | | |
| | Арга хэмжээ-3: Тохирлыг илэрхийлэх чанар, аюулгүй байдлын тэмдэгтэй бүтээгдэхүүн бий болгох замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх | Аюулгүй байдлын тэмдэгтэй бүтээгдэхүүн бий болсон байна. | - | 2021 онд: -<br>2022 онд: Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний эзлэх хувь 3%<br>2023 онд: Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний эзлэх хувь 5%<br>2024 онд: Аюулгүйн тэмдэгтэй | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв<br>Нийт: 9.0сая.төг<br>2021 онд: -<br>2022 онд: 3.0<br>2023 онд: 3.0<br>2024 онд: 3.0 | 2021 онд: аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дэргэд "Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын орон тооны бус зөвлөл"-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, хүнсний 8 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 10 үйлдвэр, хоолны газар, 5 нэр төрлийн үйлчилгээ эрхлэгч, 8 аж ахуйн нэгж, хүнсний худалдааны 2 нэр төрлийн үйлчилгээ эрхлэгч 84 ААН, 4 иргэний бүтээгдэхүүн үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон. 2022 онд "Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын орон тооны бус зөвлөл" нь 9 удаа худалдаж, 84 ААН иргэний малын мах, бялуун бүтээгдэхүүн, хүнсний худалдаа, хоол | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүтээгдэхүүний эзлэх хувь 5% | | үйлдвэрлэлийн 82 үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийсэн. 2023 онд “Бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтын орон тооны бус зөвлөл”-ийн шийдвэрээр “Баталгаажсан бүтээгдэхүүн” тэмдгийг катодын зэсийн 1, талх, нарийн боовны 1 үйлдвэрийн 4 төрлийн 19 нэрийн бүтээгдэхүүн, нийт 7 үйлдвэрийн 16 нэр төрлийн 44 бүтээгдэхүүнд хэрэглэх эрх олгосон.<br>“Жүр үр” ХХК аюулгүйн тэмдгийг бялуун бүтээгдэхүүний 12 нэрийн бялуун бүтээгдэхүүнд хэрэглэх эрхийг авч нийт бүтээгдэхүүний 2.9 хувь нь аюулгүйн тэмдэгтэйгээр зах зээлд нийлүүлэгдэж байна.<br>2024 онд "Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын орон тооны бус зөвлөл" нь 8 удаа хуралдаж, 51 иргэн, аж ахуйн нэгжийн 56 бүтээгдэхүүн, үйлчилгээнд үнэлгээ хийж, баталгаажуулалтад хамруулан тохирлын гэрчилгээ олгосон. | | |
| **Тав.Ерөнхий чиг үүргийн нэр: Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын чиглэлээр** | | | | | | | | |
| **5.1.Үндсэн чиг үүргийн нэр:** Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хөнгөн үйлдвэрийн салбарт экспортын баримжаатай болон импортыг орлох бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, үнэ цэнийн болон кластерын сүлжээг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах, хөнгөн үйлдвэрийн инноваци, технологийн шинэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт-1. Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.12/, /ЗДҮАХ-ийн 7.2.3./ | Арга хэмжээ-2: “Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх | Хөтөлбөр хэрэгжилтийн хувиар тооцно. | - | 2021 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 15%<br>2022 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 30%<br>2023 онд: Хөтөлбөри | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр<br>Нийт: -<br>2021 онд: -<br>2022 онд: -<br>2023 онд: - 20.0<br>2024 онд: - 20.0 | Аймгийн ИТХ-ын 2023 оны 14/02 дугаар тогтоолоор "Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр" батлуулан 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ төлөвлөн, дараах ажлуудыг хийж гүйцэтгэснээр хөтөлбөрийн хэрэгжилт 35.0 хувьтай байна.<br>Өрхийн үйлдвэр эрхлэгчдийг чадавжуулах сургалт зохион байгуулж, 52 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулснаар өрхийн бизнес загвараа хэрхэн гаргах | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | йн хэрэгжилт 30% | | талаар мэдлэг, мэдээлэлтэй болж зөвлөх үйлчилгээнд хамрагдсан.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүлэмж, оёдол, гутал, мах болон сүү боловсруулах чиглэлээр өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгч нийт 880 иргэнд шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн.<br>"Бялхам Ивээл" ХХК-тай хамтран дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хүлэмжийн аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхийг сайжруулах зорилгоор "Хөдөө аж ахуй технологи" сэдэвт сургалтыг зохион байгуулж, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 45 иргэнийг хамруулснаар хөрсний менежментийн болон суулгац, эрт тариалах, усалгааны, халдварт өвчнөөс сэргийлэх, улаан лооль, өргөст хэмх тариалах технологийн мэдлэгтэй болсон. Мөн Сэлэнгэ аймгийн Баруунхараа суманд хүлэмжийн аж ахуйн туршлага судлах аялалд өрхийн тариаланчдыг хамруулсан.<br>"Эрдэнэтэд үйлдвэрлэв-2023" үзэсгэлэн худалдаа 3 хоног зохион байгуулагдаж, 45 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч оролцсон.<br>2024 онд өрхийн болон бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих Шинэ хөдөө-Орхон төслийн хүрээнд 17 нэр төрлийн 29 тоног төхөөрөмж, 100 ширхэг хүлэмжийг өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд гэрээгээр эзэмшүүлсэн.<br>Аймгийн өрхийн болон бичил, жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тусгай сангаас 7 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид 265.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон. | | |
| | | | | 2024 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 30% | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, өдөрлөг, арга хэмжээг А.Амарын талбайд зохион байгуулж, үндэсний хувцас, эсгий гар урлалын бүтээгдэхүүн, эрүүл мэндийн цай үйлдвэрлэл, шүрэн эдлэл, арьсан эдлэл, төмөр хийц, уран дархан мужаан, эко саван үйлдвэрлэл, уран зураг, бичлэг зэрэг өрхийн болон жижиг дунд бизнес эрхэлдэг 44 иргэн, аж ахуй нэгж оролцож, 37.7 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.<br>Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Алтан намар-2024” нэгдсэн үзэсгэлэн худалдаанд 6 өрхийн тариаланч оролцож 108.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.<br>Хөтөлбөрийн хэорэгжилт 100 хувь. “Хойд бүсийн түншлэл-2024” орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд Орхон, Булган, Хөвсгөл аймгийн 110 үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж оролцсон. | | |
| Зорилт-2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.12/, /ЗДҮАХ-ийн 7.2.4./ | Арга хэмжээ-1: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг зээлийн бодлогоор дэмжин ажиллах | Зээлийн бодлого, дэмжлэгийн мөнгөн дүн | 7 төсөл 481.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. | 2021 онд: 500.0 сая төгрөгийн зээлд хамруулна.<br>2022 онд: 500.0 сая төгрөгийн зээлд хамруулна.<br>2023 онд: 500.0 сая төгрөгийн зээлд хамруулна.<br>2024 онд: 500.0 сая | Эх үүсвэр: Улсын төсөв болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр<br>Нийт: -<br>2021 онд: -<br>2022 онд: -<br>2023 онд: -<br>2024 онд: - | 2021 онд: Монгол Улсын ЗГ-аас хэрэгжүүлж буй ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 14-н аж ахуйн нэгж, 194 иргэнд 2.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Сум хөгжүүлэх сангаас ХАА-н чиглэлээр 7 иргэн 61.0 сая төгрөг, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 5 иргэн, аж ахуйн нэгжид 60 сая төгрөгийг хөнгөлөлттэй зээлээр дэмжсэн. 2022 онд: ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийг хөтөлбөрт 9 аж ахуйн нэгж, 53 иргэн хамрагдаж нийт 4,3 Тэрбум төгрөгийн зээл олгогдсон. -ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлд 2 аж ахуйн нэгж хамрагдаж 194,3 сая төгрөгийн санхүүжилт авсан. 2023 онд Хүнсний болон хөдөө аж ахуйн | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төгрөгийн зээлд хамруулна. | | үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөс 22 аж ахуйн нэгж, 18 иргэнд нийт 14.2 тэрбум, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 5 аж ахуйн нэгжид нийт 894.0 сая төгрөгийн зээл олгосон.<br>Хоршоо хөгжүүлэх сангаас мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 15 иргэн, аж ахуйн нэгжид 315.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.<br>Эрдэнэт хивс" ХХК нь 8 нэр төрлийн бүтээгдэхүүн экспортод гаргаж байна. Мөн "Эрдэнэт кашмер" ХХК нь 2023 онд нэхэх, сүлжих цехийн хүчин чадлыг сайжруулсан.<br>"Мөнх баян алт" ХХК нь Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Progress төслөөс хонины ноосон эсгий тавчик, эсгий дотортой арьсан гутал, ажлын эсгий гутал үйлдвэрлэхээр 9.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг авч, тоног төхөөрөмжөө шинэчлэн бүрэн автомат үйлдэлтэй болгосноор шинээр 6 ажлын байрыг бий болгон 13 ажлын байр хадгалагдаж, жилд 2500-3000 хос эсгий табчик үйлдвэрлэн экспортолж байна<br>2024 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 8 аж ахуйн нэгж 1,271.5 сая төгрөг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлээс 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоо 250.0 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 30 хоршоо 4,937.2 сая төгрөг, нийт 43 аж ахуйн нэгжид 7,358.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдож, 55 шинэ ажлын байр нэмэгдсэн.<br>Хүнсний үйлдвэрийн 17 нэр төрлийн 29 тоног төхөөрөмжийг өрхийн үйлдвэрлэл | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрхлэгч 29 иргэнд сонгон шалгаруулалтаар гэрээгээр эзэмшүүлсэн. | | |
| **Зургаа.Ерөнхий чиг үүргийн нэр: Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны чиглэлээр** | | | | | | | | |
| **6.1.Үндсэн чиг үүргийн нэр:** Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, ахуйн үйлчилгээний салбарын санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгийн бодлогын хэрэгжилтийг хангах чиг үүрэг хүлээнэ. | | | | | | | | |
| Зорилт-1. Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.12/, /ЗДҮАХ-ийн 7.2.3./ | Арга хэмжээ-1: “Эрдэнэт үйлдвэрлэл” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Хөтөлбөр хэрэгжилтийн хувиар тооцно. | Хөтөлбөрийн хэрэгжилт 70% | 2021 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 100%<br>2022 онд: шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ. 20%<br>2023 онд: Хэрэгжилт 50%<br>2024 онд: Хэрэгжилт 100% | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр<br>Нийт: 191.0 сая.төг<br>2021 онд: 41.0<br>2022 онд: 50.0<br>2023 онд: 50.0<br>2024 онд: 50.0 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны Ээлжит X хуралдаанаар "Эрдэнэт үйлдвэрлэл" дэд хөтөлбөр батлагдсан. Тус хөтөлбөр нь 2018-2021 онд 94.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.<br>"Эрдэнэт үйлдвэрлэл" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр "Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр"-ийг аймгийн ИТХ-ын 2023 оны 14/02 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна.<br>Тус хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж Эрдэнэт үйлдвэрлэв төвийн худалдаа үйлчилгээний барилгын зураг төсөв хийх тендерт "Эрдэнийн хүчит суурь" ХХК шалгарч, барилгын зураг төсвийг боловсруулан хүлээлгэн өгсөн. Мөн барилга барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Сэнгүн констракшн” ХХК шалгаран ажил эхлээд байна. | 100 | 100 |
| Зорилт-2. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамрагдаж хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад | Арга хэмжээ-1: Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах | Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээнд олгосон зээлийн хэмжээ | 1.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. | 2021 онд: Хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна.<br>2022 онд: Хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна.<br>2023 онд: Хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна. | Эх үүсвэр: Улсын төсөв<br>Нийт: -<br>2021 онд: -<br>2022 онд: -<br>2023 онд: -<br>2024 онд: - | 2021-2022 онд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөс 9 аж ахуйн нэгжид 3.1 тэрбум, 53 иргэнд 1.2 тэрбум буюу нийт 4.3 тэрбум төгрөг, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 1 аж ахуйн нэгжид 94.3 сая төгрөг, аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлд 1 аж ахуйн нэгж хамрагдаж 50.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгож 33 ажлын байр хадгалагдаж, 4 ажлын байр шинээр нэмэгдсэн.<br>2023 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас журмын шаардлага | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| дэмжлэг үзүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.13/, /ЗДҮАХ-ийн 7.2.1./ | | | | 2024 онд: Хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна. | | хангасан 5 төсөлд 894.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 27 иргэн, аж ахуйн нэгжид 533.0 сая төгрөгийн зээл олгосон. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 22 аж ахуйн нэгж, 18 иргэнд нийт 14.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдоод байна.<br>2024 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 8 аж ахуйн нэгж 1,271.5 сая төгрөг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлээс 3 аж ахуйн нэгж 1,100.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоо 250.0 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 30 хоршоо 4,937.2 сая төгрөг, нийт 44 аж ахуйн нэгжид 7,558.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. | | |
| | Арга хэмжээ-2: Бизнес эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлэх | Бизнес эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан тоо, мөнгөн дүн | 388.0 сая төгрөгийн зээл, 532.5 сая төгрөгийн батлан даалтад хамруулсан. | 2021-2024 онд: Төсөл хөтөлбөрх өнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээнд хамруулна. | Эх үүсвэр: Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр<br>Нийт: -<br>2021 онд: -<br>2022 онд: -<br>2023 онд: -<br>2024 онд: -7700.0 | 2022 онд Орхон аймгийн ЗДТГ, Эрдэнэт ШУТП-Бизнес хөгжлийн төв, Германы Олон Улсын Хамтын ажиллагааны Нийгэмлэгийн-Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих "PROGRESS" төсөлтэй хамтран жижиг, дунд үйлдвэр эрхлэгч 38 иргэн, аж ахуйн нэгжийг нийт 320.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамруулсан.<br>2023 онд Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, ШУТП-Бизнес хөгжлийн төв, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих GIZ-PROGRESS төслөөс 15 аж ахуйн нэгжид 100.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн санхүүжилт, "Хөгжлийн шийдэл" Төрийн бус байгууллагын BEST хөтөлбөрөөс 5 аж ахуйн нэгжид 50.0 сая төгрөгийн | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санхүүжилт олгосон. Жайка төслөөс 4 төсөлд 3.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүлэмж, оёдол, гутал, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах зэрэг чиглэлээр өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгч 880 иргэн, аж ахуйн нэгжид шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн.<br>2024 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 8 аж ахуйн нэгж 1,271.5 сая төгрөг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлээс 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоо 250.0 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 30 хоршоо 4,937.2 сая төгрөг, нийт 43 аж ахуйн нэгжид 7,358.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон. 23 бизнес эрхлэгч 507.0 сая төгрөгийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан. | | |
| Зорилт-3. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлнэ. /ЗДҮАХ-ийн 7.2.2./ | Арга хэмжээ-1: Ахуйн үйлчилгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 1.Мэдээллийн сангийн баяжилт /нэр төрөл/<br>2.Явуулын ахуйн үйлчилгээ зохион байгуулсан байна.<br>3.Чадавхижуулах сургалтад | Ахуйн үйлчилгээний салбарын мэдээллийн сан бий болгож, 23 нэр төрлийн үйлчилгээ хамрагдсан. | 2021 онд: Хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлнэ.<br>2022 онд: Хөтөлбөрийн хэрэгжилтийг 40%-д хүргэнэ.<br>2023 онд: Хөтөлбөрийн хэрэгжилти | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр<br>Нийт: 100.0 сая.төг<br>2021 онд: 10.0<br>2022 онд: 10.0<br>2023 онд: 10.0<br>2024 онд: 20.0 | "Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 11 арга хэмжээг тусган хэрэгжилтийг ханган ажилласнаар хөтөлбөрийн хэрэгжилт 60 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Өөрийгөө хөгжүүлэх нь", "Амжилтын 10000 цагийн төлөвлөгөө" сэдэвт сургалтад 50 гаруй хүн хамрагдаж мэдээлэл авсан.<br>Жаргалант сумын ЗДТГ, мэргэжлийн холбоодтой хамтран "Явуулын ахуйн үйлчилгээ"-г Дулаан-Уул багийн Баруунбулагт зохион байгуулж гутал | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | | йг 60%-д хүргэнэ.<br><br>2024 онд: Хөтөлбөрийн хэрэгжилтийг 100%-д хүргэнэ. | | засвар, цаг засвар, үсчин, маникюр, гар урлалын 5 чиглэлээр 100 гаруй хүнд үйлчилгээ үзүүлэв. Үсчин, гоо засалч, хумс засалч, нүүр будагч мэргэжлээр ажиллаж, сурч хөдөлмөрлөж байгаа иргэдийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, салбарын шинэ чиг хандлагыг таниулан сурталчлах, нэвтрүүлэх зорилгоор Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран аймгийн Үсчин, гоо засал, хумс урлалын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж, тэмцээнд 17 төрөлд 109 хүн амжилттай оролцсон. Аймгийн хэмжээнд ахуйн үйлчилгээний салбарт 346 цэгт аж ахуйн нэгж, иргэн үйл ажиллагаа явуулж байгаагийн 4.0 хувь нь нийтийн халуун ус, 23.1 хувь нь үсчин, гоо сайхан 24.6 хувь нь хувцас захиалга, засвар, 1.4 хувь нь гэрэл зураг авах, угаах, 0.9 хувь нь хими цэвэрлэгээ, угаалга, 0.9 хувь нь ахуйн электрон, цахилгаан хэрэгсэл засвар, 6.9 хувь нь гутал захиалга, засвар, 5.5 хувь нь гэр ахуйн модон эдлэл захиалга, засвар, 2.3 хувь нь алт, мөнгө, үнэт эдлэлийн захиалга, засвар, 30.6 хувь нь бусад үйлчилгээний чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулж байна.<br>Ахуйн үйлчилгээ хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулан ажилласнаар 2023 оны байдлаар 72 хувийн хэрэгжилттэй.<br>2024 онд "Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай" аймгийн Засаг даргын А/288 захирамжаар 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилт 9 арга хэмжээ зохион байгуулахаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу<br>1.Аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн холбоодтой хамтран ахуйн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээ эрхлэгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 5 удаагийн сургалтыг зохион байгуулан, давхардсан тоогоор 254 хүн хамруулж, үсний шинэ загварын тайралт, будалтын технологийг эзэмшиж, орчин үеийн чиг хандлага өвөрмөц урсгалуудыг орон нутгийн үсчин, гоо сайхны үйлчилгээнд нэвтрүүлэх ур чадвар эзэмшсэн.<br>2.Монголын Үсчин гоо, засалчдын үндэсний холбоотой хамтран “Төв болон хангайн бүс-2024” үсчин, гоо сайхан, хумс засалч дизайн урлалын мэргэжлийн аварга шалгаруулах бүсийн тэмцээнийг Орхон аймагт зохион байгуулсан. Тэмцээнд 6 аймгийн 100 гаруй төлөөлөл оролцсоноос Орхон аймгийн Үсчин, гоо засалчдын холбоо нь тус тэмцээнд 13 төрөлд 19 медаль /алт 8, мөнгө 6, хүрэл 5/ хүртэж “Шилдэг аймаг”-аар шалгарсан.<br>3.Ахуйн үйлчилгээний салбарт бизнес эрхлэгчдийг бүтээгдэхүүнийг иргэдэд таниулах, сурталчлах зорилгоор Амарын талбайд үзэсгэлэн худалдаа, загварын үзүүлбэрийг зохион байгуулж, үндэсний хувцас үйлдвэрлэгчид, эсгий гар урлалын бүтээгдэхүүн, эрүүл мэндийн цай үйлдвэрлэл, шүрэн эдлэл, арьсан эдлэл, төмөр хийц, уран дархан мужаан, эко саван үйлдвэрлэл зэрэг чиглэлээр 40 гаруй иргэн, аж ахуй нэгжийг хамруулж нийт 37.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.<br>4.Жаргалант сумын иргэдэд ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээг зах зээлийн үнээс хямд, нэг цэгээс хүрч үйлчлэх, иргэдийн зардлыг хэмнэх, үйлчилгээ эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын ахуйн үйлчилгээг” сумын Соёлын төвд зохион байгуулсан. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5.Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор "Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт" орсон 16 төрлийн үйлчилгээ байдгаас халуун ус, сауны үйлчилгээ тохирлын баталгаанд заавал хамруулахаар заасан. Стандартын үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэн мэргэжлийн зөвлөмж туслалцаа үзүүлж, стандартын шаардлага хангасан сауны үйлчилгээ эрхэлдэг Цацал, Дэнж, Чарминг, үсчин, гоо сайхны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Марал”, "Shine", “Charming ", “Нэмэх гоёл” “Чамин” зэрэг 5 иргэн, аж ахуйн нэгжийн нийт 8 үйлчилгээний газарт 2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээг олгосон.<br>6.“Эрдэнэтийн ээжүүдийг чадавхжуулах” ГҮТББ-тай хамтран Хойд болон Төвийн бүсийн гар урлаачдын дунд “Уран гар-2024” гар урлалын бүтээлийн уралдаан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан.<br>Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь. | | |
| | Арга хэмжээ-2: Ахуйн үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтийн түвшинг дээшлүүлэх эд сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж, тохирлын | Тохирлын үнэлгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | Шаардлага хангасан үйлчилгээний хувь 20% | 2021 онд: 5 үйлчилгээ<br>2022 онд: 10 үйлчилгээ<br>2023 онд: 10 үйлчилгээ<br>2024 онд: 20 үйлчилгээ | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв<br>Нийт: 6.0 сая.төг<br>2021 онд: -<br>2022 онд: 2.0<br>2023 онд: 2.0<br>2024 онд: 2.0 | 2021 онд: Үсчин гоо сайхны үйлчилгээний шинээр мөрдөгдөж эхэлсэн "Үс засах үйлчилгээ" MNS 5160:2020, "Хумс засал үйлчилгээ" MNS 6843:2020 стандартын сургалт зохион байгуулах ажлыг Стандарт хэмжил зүйн хэлтэс, Хөгжлийн шийдэл ТББ-аас хэрэгжүүлж буй BEST хөтөлбөр, мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулсан. Энэ онд ахуйн үйлчилгээний чиглэлээр 3 аж ахуйн нэгж 1-2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээ олгогдсон.<br>2022 онд: 8 багийн 71 цэг салбар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн Спорт цогцолбор, “Бат түшигт хан” ХХК-ны халуун ус, сауны үйл ажиллагааг хянан халуун усны үйлчилгээ MNS 5163:2002, сауны үйлчилгээ MNS 5164:2010 стандартын шаардлагыг | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үнэлгээнд хамруулах | | | | | хангасан тул халуун ус 2 жил, саун 1 жилийн хугацаатай, үсчин, гоо сайхан, хумс заслын “Чамин” салон ”Үс засах үйлчилгээ” MNS 5160:2020, “Хумс заслын үйлчилгээ” MNS 6843:2020 стандартын шаардлагыг хангаж 2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээг олгосон. "Сэрвэн цахир" , "Үзэм гоо" , "Жавхлан" , "Сувд гоо" , "Болор" зэрэг нийт 5 үсчний газар тохирлын гэрчилгээ олгоод байна.<br>2024 онд Стандарт хэмжилзүйн хэлтэст тохирлын гэрчилгээ шинээр авах болон сунгуулах хүсэлт өгсөн 5 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, шаардлага хангасан сауны үйлчилгээ эрхэлдэг Цацал, Дэнж, Чарминг, үсчин, гоо сайханы үйл ажиллагаа явуулдаг “Марал”, "Shine", “Charming ", “Нэмэх гоёл” “Чамин” зэрэг нийт 8 үйлчилгээний газарт 2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээг олгосон. | | |
| | Арга хэмжээ-3: “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III”-ийг хэрэгжүүлэх | 1.Чадавхижуулах сургалтад хамрагдсан хоршоодын тоо<br>2.Загвар хоршоо байгуулагдсан байна. | Улсын бүртгэлтэй 70 хоршоо, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 23 хоршоо байна. | 2021 онд: Чадавхижуулах сургалтад 15 хоршоог хамруулна.<br>2022 онд: Чадавхижуулах сургалтад 15 хоршоог хамруулна.<br>2023 онд: Чадавхижуулах сургалтад 15 хоршоог хамруулна.<br>2024 онд: Загвар | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв<br>Нийт: -<br>2021 онд: -<br>2022 онд: -10.0<br>2023 онд: -10.0<br>2024 онд: -20.0 | 2021 онд: Хоршоодын гишүүд болон хоршоо шинээр үүсгэн байгуулагчтай иргэдэд "Хоршооны тухай ойлголт" , "Татварын ерөнхий хууль" , "ХАА-н гаралтай бараа түүхий эд биржийн тухай хууль" , "Хоршооны сайн засаглал ба анхаарах асуудал" , "Төрийн худалдан авалтад бүтээгдэхүүн нийлүүлэх" зэрэг чадавхжуулах 5 сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 10 хоршооны 60 төрлийг хамруулсан. 2022 онд: "Хоршооны хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан "Хоршооны хөгжлийг дэмжих жил 2022" Нээлтийн арга хэмжээ, "Хоршоологчдын зөвлөгөөн" зохион байгуулж давхардсан тоогоор хоршоодын 150 төлөөлөл оролцож холбогдох мэдээлэл авсан. ХАА-н бирж ХХК Хоршооллын сургалт мэдээллийн төв, ХАА-н хоршоологчдын холбоотой хамтран | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хоршоо байгуулагд сан байна. | | 4 удаагийн цуврал сургалт зохион байгуулж давхардсан тоогоор нийт 310 иргэн хоршоодын төлөөлөл хамрагдсан.<br>2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хоршоог хөгжүүлэх чиглэлээр 6 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан<br>“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III”-ыг орон нутагт хэрэгжүүлэх Аймгийн Засаг даргын 2024 оны “Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай” А/194 дүгээр захирамжаар 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилт 11 арга хэмжээ зохион байгуулж хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.<br>Монгол Улсын Засгийн газраас санаачилсан “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд мал аж ахуйн чиглэлийн 39 хоршоо шинээр байгуулагдаж, 40 хоршооны гишүүн малчид 5,597.2 сая тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдаж тоног төхөөрөмж, үржлийн мал худалдан авч малын сүргийн бүтцийг сайжруулах, малын тэжээл тариалах зориулалтаар зээл авсан байна. Мөн 40 хоршооны гишүүн 150 малчин өрх 3.9 тэрбум төгрөгийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан.<br>Хоршоо хөгжүүлэх сангаас 2024 онд Баян-Өндөр сумын мал аж ахуйн чиглэлийн Арга билиг арвин сүрэг хоршоо 100.0 сая, Лууснын дагина хоршоо 50.0 сая, Жаргалант сумын БЛГЯ хоршоонд 100.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан ажлын байрны өргөтгөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдэн 28 ажлын байр хадгалагдаж, 5 ажлын байр шинээр нэмэгдсэн байна. | | |

| Долоо.Ерөнхий чиг үүргийн нэр: Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **7.1.Үндсэн чиг үүргийн нэр:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төсөв боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, санхүүгийн байдлыг тайлагнах, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх, төсвийн шууд захирагчийн төсвийн төсөл, хөрөнгө оруулалт, зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөх, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийг захиран зарцуулах, тайлагнах, зохицуулалтыг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, төсвийг ил тод мэдээлэх, гадаадын төсөл, хөтөлбөрийн төсвийн нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтыг хангах, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг тасралтгүй явуулах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд хариуцах чиг үүргийг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт-1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.11/ | Арга хэмжээ-1: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс олгох татаас, мөнгөн урамшууллын хэрэгжилтийг ханган ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Улаанбуудай тариалдаг 6 ААН, 1 иргэний гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн 6127 тн улаан буудайд Арьс, ширний урамшуулалд 219 өрхийн 5310 ширхэг арьс ширэнд | 2021 онд: Үйлдвэрт нийлүүлсэн хүнсний улаанбуудай, ноос, ноолуур, арьс шир, сүү урамшуулал олгоно.<br>2022 онд: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс олгох дэмжлэг, мөнгөн урамшууллад иргэн, аж ахуй нэгжийг хамруулна. | Эх үүсвэр: Улсын төсөв Нийт: -<br>2021 онд: -<br>2022 онд: -<br>2023 онд: -<br>2024 онд: - | 2021 онд: ЗГ-ын 2019 оны 343 дугаар тогтоолоор баталсан "Хонь тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журмын шаардлага хангасан Орхон аймгийн Баян-Өндөр Жаргалант сумын 48 малчин мал бүхий этгээд 7.1 тн хонины ноосыг " Эрдэнэт текс" ХХК-д нийлүүлж 10.6 сая төгрөгийн урамшуулалд хамрагдсан байна. Баян-Өндөр сум 23000 толгой ямаанаас 7200кг ноолуур, Жаргалант 29000 толгой ямаанаас 9100 кг буюу нийт 16300 кг ноолуур бэлтгэсэн. 2022 онд: Малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд үйлдвэр цехэд малын түүхий сүү нийлүүлэхэд цахим бүртгэлийн талаарх сургалтыг 2022 оны 11 дүгээр сард МЭГ, Татварын хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Үүнд: 11 фермер эрхлэгч, 5 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд хамрагдсан. 2023 онд Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем plant.mofa.gov.mn цахим системд аймгийн | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 29.1 сая төгрөг, ноосны 49 өрхийн 6970 кг ноосонд 10.4 сая төгрөг, Ноолуур 540 өрхийн 13.5 мянган кг ноолуурand 270.0 сая төгрөгийн урамшуулал олгосон | 2023-2024 онд: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс олгох дэмжлэг, мөнгөн урамшууллд иргэн, аж ахуй нэгжийг хамруулна. | | хэмжээнд 468 нэгж талбарын 5239 га тариалангийн талбай, 308 иргэн, 28 аж ахуйн нэгж бүртгүүлсэн Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 563 иргэн, 12 аж ахуйн нэгжийн тариалалтын мэдээг таримал тус бүрээр нь аймгийн статистик мэдээтэй тулган баталгаажуулалт хийсэн. 2022 онд ургацын цахимаар илгээгдсэн 175 удаагийн урамшууллын хүсэлтэд 900.0 сая төгрөгийн урамшууллыг 7 аж ахуйн нэгж, 135 иргэн авсан. “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам” -аар 2023-2024 оны сүү хүлээн авах үйлдвэр, цехийн сонгон шалгаруулалтад Баяжуулагч одод ХХК, Эрдэнэт хаан сүү ХХК-ууд тэнцэж, Баяжуулагч одод ХХК Орхон, Булган, Дархан, Сэлэнгийн 34, Эрдэнэт хаан сүү ХХК Орхон, Сэлэнгийн 10 малчин, фермертэй гэрээ байгуулсан. Баяжуулагч одод ХХК-ийн сүүний үйлдвэрт 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд 50 малчин, фермер 47,451 литр сүү нийлүүлж, 23.7 сая төгрөгийн урамшуулал олгогдсон. | | |
| **БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ** | | | | | | | **99.2** | **99.2** |

ОРХОН АЙМАГ ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР